

2020.04.08

№

317

танай

ны №


-т

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг  
зарласан тогтоол, мэдэгдлийг хүргүүлэх тухай

“Монос хүнс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хурлаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр цахим хэлбэрээр хуралдуулахаар товлосон бөгөөд холбогдох хууль, эрх зүйн бусад актад заасны дагуу тогтоолын эх хувийг, СЗХ-ы 2018 оны 12 сарын 14 өдрийн 377 тоот “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын 1 дүгээр хавсралтад заасан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийн хамт хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



А.ОТГОНДАРЬ



+976 77738525



foods@monos.mn  
www.monosfoods.mn



Чингисийн ергэн чөлөө 203 13, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар хот 17043, Монгол Улс

# “МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 06-ний өдөр

№ 10/04

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг  
цахим хэлбэрээр хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйл, 65 дугаар зүйл, 76-р зүйлийн 76.1.2, 76.1.3 заалт, Улсын онцгой комиссын 2020 оны 3 дугаар сарын 20 өдрийн 13 тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын 5 өдрийн “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах тухай” зөвлөмж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 6-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монос хүнс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 15 цагт цахим хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр хийх болсонтой холбоотой Хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх зарын загварыг Хавсралт №01-ээр батлан, Монголын Хөрөнгийн Бирж болон компанийн цахим хуудас, өдөр тутмын сонин, телевизээр дамжуулан нийтэд мэдээлсүгэй.
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж, зохион байгуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ажиллахыг Хурлын дарга /Б.Гантулга/, Хурал зохион байгуулах комисс /Комиссын дарга П.Тодрол/, Гүйцэтгэх захирал /А.Отгондарь/ нарт тус тус үүрэг болгосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр хийх тогтоол, мэдэгдлийг 2020 оны 4 сарын 9 өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичиг /Н.Цагаанхүү/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.ХҮРЭЛБААТАР

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар хийх зарын загвар**

/Сонин, телевиз, компанийн болон БДК-ын вэбсайтад байршуулах /

**МОНОС ХҮНС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

Монос хүнс ХК нь шинэ төрлийн коронавирусын /COVID-19/ болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 сарын 27 өдрийн 15 цагаас цахим хэлбэрээр хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигч та 2020.04.10 – 2020.04.24-ны өдрүүдэд Монос хүнс компанийн хуурай хүнсний үйлдвэрийн байранд өөрийн биеэр /иргэний үнэмлэх авчрах/ ирж бүртгэлээ хийлгэн, цахим хурлын хаяг, түүнд нэвтрэх нэр, санал өгөх нууц кодоо авна уу.

Монос хүнс компанийн хуурай хүнсний үйлдвэрийн байршил:

Хан-уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, 20 дугаар хороо 201 /Мишээл экспо худалдааны төвийн баруун талд, Тэнгэр дээд сургуулийн урд/

Дэлгэрэнгүй мэдээллийг 99035178, 88080308 утсаар холбогдон авна уу.

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	МОНОС ХҮНС ХК
Хаяг:	ХУД, Чингисийн өргөн чөлөө, 205/2 тоот
Хурал хуралдах өдөр, цаг:	2020 оны 04 сарын 27, 15:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	meeting.monosfood.mn цахим хуудас
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	ТУЗ
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2020 оны 04 сарын 06
Олон нийтэд зарлах огноо:	2020 оны 04 сарын 07
Бүртгэлийн өдөр:	2020 оны 03 сарын 11
Хурлын баримт бичгийг БДК-д хүргүүлэх огноо:	2020 оны 03 сарын 06
Хүргүүлсэн огноо:	2020 оны 03 сарын 06
Хурлын даргын нэр:	ТУЗ хараат бус гишүүн Б.Гантулга
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Дарга Э.Амарболд Гишүүд Б.Бархас, Ц.Дөлгөөнмайдар
Баримт бичгийн жагсаалт	<ol style="list-style-type: none"> <li>1. Монос хүнс ХК-ийн ХЭ-ийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2020-02-18 өдрийн тогтоол</li> <li>2. ХЭ-ийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр хуралдуулах тухай ТУЗ-ийн 2020-04-06 өдрийн тогтоол</li> <li>3. ХЭ-ийн хурлын зарын загвар</li> <li>4. Монос хүнс ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны тайлан</li> <li>5. Монос хүнс ХК-ийн 2019 оны санхүүгийн аудитлагдсан тайлан</li> <li>6. Монос хүнс ХК-ийн ТУЗ гишүүдийн танилцуулга</li> <li>7. Компанийн ТУЗ-ийн 2020 оны төсвийн санал</li> <li>8. Компанийн болон бүтээгдэхүүний танилцуулга /товхимол/</li> <li>9. ХЭ-ийн хурлын дэг</li> <li>10. ХЭ-ийн хурлын саналын хуудас</li> <li>11. ХЭ-ийн хурлаас гарах шийдвэрийн төсөл</li> </ol>
Баримт бичгийн хуудасны тоо:	..... хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

\_\_\_\_\_ /П.ТОДРОЛ/  
 2020 оны 04 сарын 06 өдөр

